

# ХҮЧЭЭ НЭГТГЭЭ!



МОНГОЛ  
АРДЫН НАМ

АЙМАГ, СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛСЭН  
**“ТОГТВОРТОЙ БОДЛОГО  
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ”**  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 он

## ХҮНДЭТ ДАРХАНЧУУД АА!

Дархан-Уул аймгийн Монгол Ардын Намын гишүүд, дэмжигчид бид Дарханчууд Та бүхэндээ “ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ” уриа бүхий “ТОГТВОРТОЙ БОДЛОГО – ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ” мөрийн хөтөлбөрөө өргөн барьж байгаадаа баяртай байна.

Бид энэ удаагийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Дархан хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө /2020-2035 он/ болон бусад хөгжлийн суурь баримт бичгүүдийн зорилго, зорилтуудтай уялдуулан иргэдийн санал, эрэлт шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

Мөрийн хөтөлбөрийн гол үзэл баримтлал нь хүнээ хөгжүүлэх замаар хот, орон нутгийн хөгжлийг хурдасгаж, шинжлэх ухааны ололт, шинэ техник, технологи, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн хөгжлийн тэргүүлэх салбаруудыг бодлогоор дэмжиж, нэмүү өртөг шингэсэн үйлдвэржилтийн тогтвортой бодлого барьж, ажлын байруудыг бий болгон иргэдээ ажилтай, орлоготой байлгаж амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэж байгаа юм.

Энэ ч утгаараа манай намын мөрийн хөтөлбөр нь эрдэмтэд, судлаачдын судалгаа, эдийн засгийн тооцоолол дээр суурилсан, хэрэгжих бүрэн боломжтой, аймаг, хотын цаашдын хөгжлийг хурдасгах бодлогын баримт болж чадсан гэж бид үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу аймаг маань улсын зэрэглэлтэй хот болж байгаатай холбогдуулан ирээдүйд хот болон хөгжих нөхцөл, шаардлагыг ч харгалзан үзсэн болно.

Мөн түүнчлэн ард иргэдийнхээ аж амьдралыг сайжруулах чиглэлээр өмнө нь хэрэгжүүлж байсан төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын ажлын шууд үргэлжлэл болж буйгаараа онцлог юм.

Манай нам бүхий л цаг үед ард иргэдийнхээ өмнө хариуцлагаа гүнээ ухамсарлаж, тэднийхээ итгэлийг дааж, Дархан нутгийнхаа үүсэл, хөгжлийн түүчээ нь байж ирсэн бөгөөд цаашид ч хөгжилд хөтөлгөч гол улс төрийн хүчин байж чадна гэдгээ илэрхийлж байна.

Нийт Дарханчууд Та бүхнийгээ Монгол Ардын Намаас дэвшүүлсэн мөрийг хөтөлбөртэй сайтар танилцаж, улмаар аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгох сонгуульд дэмжиж саналаа өгнө гэдэгт итгэж байна.

Төр тогтвортой байснаар төрийн бодлогын залгамж чанар тогтвортой хадгалагдаж, хөгжил тогтвортой, хурдацтай байх болно.

**ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ!**

## АГУУЛГА

### НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ

- 1.1 Эрүүл иргэн
- 1.2 Чанартай боловсрол
- 1.3 Тогтвортой гэр бүл
- 1.4 Хөдөлмөрийн зах зээл
- 1.5 Зорилтот бүлэг
- 1.6 Шинжлэх ухаан, соёл урлаг, спорт

### ХОЁР. НОГООН ХӨГЖИЛ

- 2.1 Байгаль хамгаалал
- 2.2 Ногоон эдийн засаг
- 2.3 Ногоон үйлдвэрлэл, үйлчилгээ

### ГУРАВ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛ

- 3.1 Үйлдвэрлэлийн бодлого
- 3.2 Бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- 3.3 Борлуулалт, зах зээл

### ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

- 4.1 Хотын хөгжил
- 4.2 Сумдын хөгжил

### ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 5.1 Иргэдэд ээлтэй төрийн үйлчилгээ
- 5.2 Ухаалаг төрийн үйлчилгээ
- 5.3 Эрх зүйн бодлого

### ЗУРГАА. ХАВСРАЛТ

(Нийт 5 бүлэг, 17 дэд бүлэг, 215 зорилт)

## Нэг. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Эрүүл мэндийн чанар, хүртээмжийг сайжруулж, хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, хүн амын тогтвортой, өсөлт, хөгжлийг дэмжиж, идэвхтэй, бүтээлч, ажилтай, орлоготой иргэн, гэр бүлийг төлөвшүүлэн хүний амьдралын чанарыг сайжруулна.

### 1.1 Эрүүл иргэн

1.1.1 “Эрүүл Дарханчууд” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.1.2 “Эрүүл ирээдүй”, “Эрүүл шүд” дэд хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

1.1.3 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр орон нутагтаа тусгайлсан бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

1.1.4 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай, ил тод, хариуцлагатай байлгах зорилгоор “Шилэн эмнэлэг” төслийг шинээр, “Цахим эмнэлэг” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.1.5 Орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон “Эрүүл мэндийн оношилгооны бүсийн төв” байгуулж, иргэдээ жил бүр эрүүл мэндийн иж бүрэн оношилгоонд хамруулан эмчилгээ, оношилгооны чанар, хүртээмжийг сайжруулна.

1.1.6 Эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, үйлчлүүлэгчдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх орчныг сайжруулна.

1.1.7 “Энх бүсгүй” хөтөлбөр хэрэгжүүлж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг онцгойлон анхаарч, эх хүүхдийн эндэгдлийг бууруулна.

1.1.8 “Эрүүл чийрэг эр хүн” хөтөлбөр хэрэгжүүлж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг эрсдэлт хүчин зүйлүүдийг бууруулна.

1.1.9 Хүн амын дунд зонхилон тохиолддог өвчний тандалт судалгааг хийж, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

1.1.10 “Хавдраас урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөр” боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.1.11 Оюутан, залуучуудыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулж, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.1.12 Эрүүл мэндийн салбарын ажиллагсдыг чадавхижуулж, тэдний нийгмийн асуудлыг шат дараатай шийдвэрлэнэ.

1.1.13 “Чадварлаг сувилагч, асрагч” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.14 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн материаллаг баазыг бэхжүүлж, алслагдсан баг, гэр хороололд шинээр байгуулах, өргөтгөх замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

1.1.15 Хувийн хэвшлийн эмнэлгүүдийг дэмжих замаар хамтран ажиллана.

1.1.16 Эм зүйн салбарыг дэмжиж, эмийн бус эмчилгээний аргыг түгээн дэлгэрүүлнэ.

Хүний хөгжил

## 1.2 Чанартай боловсрол

1.2.1 Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг эрс сайжруулна.

1.2.2 Шинээр барих, өргөтгөх замаар цэцэрлэг, сургуулийн тоог нэмэгдүүлнэ.

1.2.3 Цэцэрлэг, сургууль бүрийн материаллаг баазыг сайжруулж, хүүхэд эрүүл, аюулгүй орчинд сурах нөхцлийг бүрдүүлнэ.

1.2.4 Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарын мэдлэг, чадвар, заах арга зүйг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах зорилгоор **“Ардын багш”** аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.2.5 Цэцэрлэг, сургуулийн гадна болон дотор орчны засвар үйлчилгээ, тохижилт, өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор **“Гоё цэцэрлэг”, “Гоё сургууль”** төслүүдийг хэрэгжүүлнэ.

1.2.6 Сурагчдад сонирхол, авьяас чадвараа харгалзан ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход нь мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор ахлах ангийн сурагчдын дунд **“Миний ирээдүй”** төсөл хэрэгжүүлнэ.

1.2.7 Хүүхэд хөгжлийн ордны үйл ажиллагааг дэмжиж, хүүхдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор хичээлээс гадуурх сонгон, секц, дугуйлангуудыг бодлогоор дэмжинэ.

1.2.8 Зарим томоохон байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дэргэд цэцэрлэг байгуулж, цэцэрлэгийн дотор яслийн анги нээж ажиллуулахыг дэмжинэ.

1.2.9 **“Цахим сургууль”** төсөл хэрэгжүүлнэ.

1.2.10 Төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэг, сургууль, их, дээд, мэргэжлийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.

1.2.11 Дотоод, гадаадын их, дээд сургуулиудад зарим төрлийн нэн шаардлагатай нарийн мэргэжлийн хүмүүсийг орон нутгийн захиалгаар гэрээгээр бэлтгэж, тогтвортой ажлын байраар хангах зорилгоор **“Захиалгат мэргэжилтэн”** төсөл хэрэгжүүлнэ.

1.2.12 **“Залуучуудын боловсрол, хөгжил”, “Оюунлаг Дарханчууд”** дэд хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

1.2.13 **“Боловсрол хотхон”**-ы бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ.

1.2.14 Бүх нийтийн боловсрол болон алсын зайны сургалтыг дэмжиж ажиллана.

1.2.15 Зулзагын гол дахь хүүхдийн амралтын газрыг шинэчлэн засварлаж, **өвлийн улиралд** ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

**1.3 Тогтвортой гэр бүл**

1.3.1 Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, гэр бүл дэх хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах асуудлыг бодлогоор дэмжиж ажиллана.

1.3.2 Гэр бүлийн гишүүд, ялангуяа эцэг, эхчүүдийн хариуцлагыг дээшлүүлж, хүүхэд гэр бүл дотроо амар тайван өсч хөгжих боломж, нөхцлийг хангуулна.

1.3.3 Хүүхдийг багаас нь амьдрах ухаанд сургаж, ирээдүйд харилцааны зөв хэвшилтэй, ёс зүйтэй, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхийг бодлогоор дэмжинэ.

1.3.4 “Хүний хөгжил” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3.5 “Өрхийн хөгжил” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3.6 Залуу гэр бүлийг дэмжих тусгай бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ..

1.3.7 “Оюунлаг гэр бүл”, “Ажилсаг гэр бүл”, “Авьяаслаг гэр бүл”, “Спортлог гэр бүл”, “Орлоготой гэр бүл” төслүүд хэрэгжүүлнэ

1.3.8 Гэр бүлийн бичил бизнесийг дэмжин хөгжүүлнэ.

**1.4 Хөдөлмөрийн зах зээл**

1.4.1 Аймгийн хэмжээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хөдөлмөр эрхлэлтийн судалгаа хийсний үндсэн дээр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр” боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.4.2 Ажилгүй иргэдийг мэргэжил, боловсрол, сонирхлын дагуу нэгдсэн бүртгэлд хамруулж, ажилд зуучлах замаар 6000-аас доошгүй байнгын болон түр ажлын байр бий болгоход бодлогоор дэмжиж ажиллана.

1.4.3 Ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны иргэдийг мэргэшүүлэх, ур чадварыг нь ахиулах богино хугацааны сургалтанд хамруулж, ажлын байраар хангахад бодлогоор дэмжинэ.

1.4.4 Ажлын байраа хадгалсан, шинэ ажлын байр бий болгосон ажил олгогчдыг дэмжиж ажиллана.

1.4.5 Сургалтын байгууллагууд ажил олгогчдын захиалгаар ажилтан бэлтгэх нөхцлийг бий болгож, аж үйлдвэрийн салбарт орчин үеийн шаардлагад нийцсэн нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор “Шинэ залуу халаа” төслийг гадаад, дотоодын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага болон хувийн хэвшилтэй хамтарч хэрэгжүүлнэ.

1.4.6 Оюутнуудын хичээлийн бус цагаараа хөдөлмөр эрхлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “Цагийн ажил” төсөл хэрэгжүүлнэ.

1.4.7 Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд “Дадлагын бааз” байгуулахыг бодлогоор дэмжинэ.

Хүний хөгжил

1.4.8 Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бүх талаар туслалцаа үзүүлж, бизнесээ өргөжүүлэх, тэлэх боломжоор хангана.

1.4.9 Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид, гарааны бизнес эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжиж, шаардлага хангасан аж ахуйн нэгж, иргэдэд “Итгэлийн зээл” олгоход бодлогоор дэмжинэ.

## 1.5 Зорилтот бүлэг

1.5.1 Хүүхэд, залуучууд, ахмадын хөгжлийн төрөлжсөн төвүүдийн үйл ажиллагааг бүх талаар дэмжинэ.

1.5.2 Дунд, ахмад үеийнхэн (45-аас дээш насныхан)-ий туршлага, мэдлэг, нөөц боломжийг ашиглах, тэдэнд зориулсан ажлын байр бий болгохыг дэмжиж ажиллана.

1.5.3 Тусгай хэрэгцээтэй иргэдийг хөгжүүлэх зорилго бүхий “Хөгжлийн төв” байгуулж, тохирсон ажлын байраар хангана.

1.5.4 Өрх толгойлсон эх /эцэг/ -үүдийг онцгойлон анхаарч, олон хүүхэдтэй гэр бүл, орлого багатай өрх, иргэдийг тусгай бодлогоор дэмжиж ажиллана.

1.5.5 Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг бусад үе тэнгийн насныхантайгаа хамт ердийн сургууль, цэцэрлэгт сурч, хөгжих боломжоор хангана.

1.5.6 Иргэдийн худалдан авах чадварт тохирсон орон сууцны бодлого хэрэгжүүлнэ.

1.5.7 “Түрээсийн орон сууц” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.5.8 Бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, тусгай хэрэгцээтэй иргэд, ахмад настнууд хагас цагаар, эсвэл гэрээсээ зайнаас ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

1.5.9 Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд зориулж урт хугацааны “Нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх төв” байгуулна.

1.5.10 Гарааны бизнес эрхлэгч оюутан, залуучуудад бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, дэмжлэг үзүүлэх цогц арга хэмжээг авч ажиллана.

1.5.11 Тусгай хэрэгцээтэй иргэдийн хэрэгцээт үйлчилгээгээ авах нөхцлийг бүх байгууллага, аж ахуйн нэгжүүдэд бүрдүүлнэ.

## 1.6 Шинжлэх ухаан, соёл урлаг, спорт

1.6.1 Эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийг бүх талаар дэмжиж, тэдний бүтээл туурвилыг эдийн засгийн эргэлтэнд оруулна.

1.6.2 Шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник, шинэ технологи, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхийг бодлогоор дэмжиж, энэ чиглэлд хөрөнгө оруулалт, санхүүжилт татах замаар эдийн засгийн өсөлт бий болгох төслүүдийг дэмжиж ажиллана.

1.6.3 Эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд, судлаачидтай хамтран шинэ технологи нэвтрүүлсэн, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн иргэн, аж ахуйн нэгжүүдийг урамшуулах тогтолцоог бий болгоно.

1.6.4 Эрдэмтэд, судлаачдын дунд улс, орон нутгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц бүтээл, туурвилын уралдаан зарлаж, шалгарсан бүтээлийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад дэмжлэг үзүүлнэ.

1.6.5 Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж буй сурлагын амжилтаараа тэргүүлэгч оюутнуудад зориулсан **“Тэтгэлэгт хөтөлбөр”** хэрэгжүүлнэ.

1.6.6 Номын сан, музейн цогцолбор байгуулна.

1.6.7 Спорт цогцолборын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн дуусгана.

1.6.8 **“Авьяаслаг Дарханчууд”**, **“Спортлог Дарханчууд”** дэд хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

1.6.9 Мэргэжлийн урлаг, спортын байгууллагуудын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, материаллаг баазыг нь бэхжүүлж, боловсон хүчний чадавхийг сайжруулна.

1.6.10 Оюуны өмчийн үнэлэмжийг сайжруулж, Дарханчуудын эзэмшиж буй зохиогчийн эрх, патентийн нэгдсэн сан байгуулна.

1.6.11 Түүх, соёлын үнэт зүйлс, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

1.6.12 Дархан нутгаас төрөн гарсан шилдэг тэргүүний хүмүүсийг алдаршуулах олон талт цуврал арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.6.13 Дархан нутгийн түүх, соёл, байгаль, хөгжлийн онцлогийг харуулсан урлаг, соёлын бүтээл, туурвилыг нийтийн хүртээл болгоход нь дэмжлэг үзүүлнэ.

1.6.14 Мэргэжлийн соёл, урлаг, спортын байгууллагын дэргэд хичээллэх секц, дугуйланг бодлогоор дэмжиж ажиллана.

1.6.15 Урлаг, спортын салбарыг дэмжих зорилгоор **“Дархан – Их урлаг”**, **“Дархан – Их спорт”** сангуудыг төр, хувийн хэвшлийн дэмжлэгээр байгуулна.

1.6.16 Номын сангийн фонд, музейн үзмэрийн төрөл, тоог тогтмол нэмэгдүүлнэ.



1.6.17 Хүүхэд, залуучуудын дунд шинэ тутам хөгжиж буй спортын төрлүүдийг дэмжиж, спорт талбайдыг шинээр байгуулна.

1.6.18 Багийн, оюуны болон өвлийн спортын төрлүүдийг онцгойлон дэмжиж, голлох төрлүүдээр “**Аймаг, хотын шигшээ баг**”-ийг байгуулж, төрөөс дэмжлэг үзүүлж ажиллана.

1.6.19 Хувийн хэвшилтэй хамтран урлаг, спортын “**Төрөлжсөн дунд сургууль**” байгуулна.

1.6.20 Шинээр **цэнгэлдэх хүрээлэн** байгуулж, ашиглалтын менежментийг сайжруулж, байнгын ажиллагаатай болгоно.

1.6.21 Үндэсний болон байт сурын **цогцолбор** байгуулна.

1.6.22 Сургуулиудын гадна спортын талбайнуудыг орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчилж, сайжруулна.

## Хоёр. НОГООН ХӨГЖИЛ

*Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө ба ирээдүй хойч үе хүртэх нөхцлийг бүрдүүлнэ.*

### 2.1 Байгаль хамгаалал

2.1.1 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр урт, богино хугацааны **төсөл, хөтөлбөрүүдийг** хэрэгжүүлнэ.

2.1.2 Онцлог, ховор, үнэ цэнэ бүхий экосистемүүдийг орон нутгийн хамгаалалтад авч, анхдагч байгалийн унаган төрх, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.

2.1.3 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгаалалтын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.

2.1.4 Усны нөөц, гол мөрөн, булаг шандны урсац бүрэлдэх эхийг хамгаалан хуримтлалыг бий болгож, үйлдвэрлэл, уул уурхай, хөдөө аж ахуйн салбарт ус хангамжийн менежментийг сайжруулна.

2.1.5 Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг үе шаттай хийж, зохистой менежментийг хэрэгжүүлнэ.

2.1.6 Ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойжуулах, нөхөн сэргээх, хамгаалах, ойн хомсдлоос урьдчилан сэргийлэх замаар ойн санг нэмэгдүүлж, **200**-аас багагүй га талбайд ойжуулалт хийнэ.

2.1.7 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх чиглэлээр **“Ногоон бүс”** төсөл хэрэгжүүлнэ.

2.1.8 Уул уурхай, үйлдвэрлэлийн улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг тогтмол хийнэ.

2.1.9 Тариалангийн газрын үржил шимийг сайжруулж, хөрс тордох ажлыг зохион байгуулж, бэлчээрийн зүй зохистой менежментийг хэрэгжүүлнэ.

2.1.10 Уул уурхайн лиценз олголтод орон нутгийн оролцоог нэмэгдүүлж, ашиглалтын байдалд тавих хяналтыг чангатгаж, хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.

2.1.11 Орхон, Хараа голын сав дагууд болон ойн сан бүхий газруудад тархсан хөнөөлт шавьжтай тэмцэх ажлыг **5000**-аас доошгүй га талбайд хийнэ.

## **2.2 Ногоон эдийн засаг**

2.2.1 Байгальд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай, хэмнэлттэй, дэвшилтэт ногоон технологийг нутагшуулж, ногоон эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр бүхий л санал санаачилгыг дэмжиж ажиллана.

2.2.2 Байгальд ээлтэй ногоон төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх төр, хувийн хэвшлийн хамтарсан ногоон санхүүжилтийг нэвтрүүлнэ.

2.2.3 **“Утаагүй Дархан”, “Шарилжгүй Дархан”** дэд хөтөлбөрүүд хэрэгжүүлж, агаарын бохирдолгүй хот болно.

2.2.4 Ариун цэврийн байгууламжийн чанар, хүртээмжийг сайжруулж, **“Эко жорлон”** төсөл хэрэгжүүлнэ.

2.2.5 **“Ногоон хот”** төсөл хэрэгжүүлж, ногоон байгууламж нэмэгдүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг урамшуулах тогтолцоог бий болгоно.

2.2.6 Ногоон худалдан авалтыг дэмжиж ажиллана.

2.2.7 Ойн санг гэрээгээр эзэмшигч иргэдийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжиж, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлнэ.

## **2.3 Ногоон үйлдвэрлэл, үйлчилгээ**

2.3.1 Байгалийн нөөцийн хэмнэлттэй, агаар орчны бохирдол, хаягдал багатай үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.

2.3.2 Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийг бодлогоор дэмжинэ.

2.3.3 Эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи ашиглан барилгын дулааны алдагдлыг бууруулна.

2.3.4 Эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.

2.3.5 Байгаль орчинд ээлтэй нийтийн тээврийн төрөл, үйлчилгээг хөгжүүлнэ.

2.3.6 Саарал усыг үйлдвэрлэлд дахин ашиглахыг бодлогоор дэмжинэ.

2.3.7 Үйлдвэрлэлийн болон аюултай хог хаягдлын цэгийг стандартад нийцүүлнэ.

2.3.8 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах цогц менежментийг хэрэгжүүлж, эдийн засгийн эргэлтэнд оруулж, дахин боловсруулах үйлдвэр барина.

2.3.9 **Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр** байгуулж, орон нутгийн хэрэгцээгээ бүрэн хангана.

2.3.10 Хүн амыг эрүүл, экологийн цэвэр хүнсээр хангах бодлого баримталж **“Эко хүнс” хөтөлбөр** хэрэгжүүлнэ.

## Гурав. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛ

*Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн, экспортод чиглэсэн, импортыг орлох бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимжсэн хөдөө аж ахуйтай хослуулан хөгжүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг бүх талаар дэмжинэ.*

### 3.1 Үйлдвэрлэлийн бодлого

3.1.1 Дархан хотыг хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөө (2020-2035)- тэй уялдуулан үйлдвэрлэлийг хөгжүүлэх **тусгай бодлого** боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.1.2 3.1.3 Эрх бүхий байгууллагуудтай хамтарч **Үйлдвэрлэл, технологийн паркийн** эрх зүйн орчныг сайжруулж, үйл ажиллагааг нь эрчимжүүлнэ.

3.1.3 Хүнд, хөнгөн болон боловсруулах чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээгээ орон нутгийн үйлдвэрлэлээр хангах бодлого баримтална.

3.1.4 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, тусламж, олон улсын төсөл, хөтөлбөрт хамруулахыг бодлогоор дэмжинэ.

3.1.5 Үйлдвэрлэлд шинэ менежмент, дэвшилтэт техник, технологи, ноу-хау нэвтрүүлэхийг бодлогоор дэмжинэ.

### 3.2 Бүтээгдэхүүн үйлдвэрлэл

3.2.1 Жилд 10,0 сая ширхэг арьс, шир, 15,0 мянган тонноос багагүй ноос, ноолуур боловсруулах хүчин чадал бүхий **“Дархан арьс ширний цогцолцор”**-ын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн дуусгана.

3.2.2 Мал аж ахуйг мах, сүү, ноос, ноолуурын чиглэлээр төрөлжүүлж, эрчимжсэн хэлбэрээр хөгжүүлнэ.

3.2.3 **“Атар-4”** аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.2.4 Оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

3.2.5 Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.

3.2.6 Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

3.2.7 Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин хөгжүүлнэ.

3.2.8 “Үр” дэд хөтөлбөр, “Хүлэмж”, “Зоорь”, “Бордоо” төслүүд хэрэгжүүлнэ.

3.2.9 Таримлын сэлгээ, тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, газар тариалангийн салбарт усжуулалтыг нэмэгдүүлнэ.

3.2.10 Туслах аж ахуйг дэмжин хөгжүүлнэ.

### 3.3 Борлуулалт, зах зээл

3.3.1 “Дарханд үйлдвэрлэв” нэгдсэн мэдээллийн цахим сан байгуулж, үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд борлуулах, сурталчилахад бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

3.3.2 Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг олон улсын үзэсгэлэн яармагт оролцоход нь бүх талаар дэмжиж, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3.3.3 Орон нутагтаа болон хүн ам олноор суурьшсан газруудад “Дарханд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг жил тутам зохион байгуулна.

3.3.4 Бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, зүйлээр “Дарханы бренд” –үүдийг жил бүр шалгаруулж, гадаад, дотоодод сурталчилна.

3.3.5 Орон нутгийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний дотоодын худалдан авалтыг хууль тогтоомжийн хүрээнд дэмжинэ.

3.3.6 Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгоно.

### Дөрөв. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

*Иргэдийнхээ ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг хангасан эрүүл, чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй, амар тайван, аюулгүй хот болон хөгжинө.*

#### 4.1 Хотын хөгжил

4.1.1 Дархан-Уул аймгаа Дархан хот болгон өөрчлөх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд ард, иргэдтэйгээ хамтран ажиллаж, засаг захиргааны зөв бүтэцтэй орчин үеийн хөгжлийн шийдэл бүхий хот болон хөгжих суурийг тавина.

4.1.2 Орон нутгийн давуу тал, онцлогт тулгуурлан Дархан хотоо аж үйлдвэр, үйлчилгээ зонхилсон **шинжлэх ухаан, технологи, инновацийн төв** болгон хөгжүүлнэ.

4.1.3 Хотын цэвэр ус, дулааны шугамын шинэчлэлтийг үе шаттай хийж, усан хангамж, дулаан, эрчим хүчний найдвартай ажиллагааг хангуулна.

4.1.4 Орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, нийтийн орон сууцуудын засвар үйлчилгээг үе шаттай хийж, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.

4.1.5 Ерөнхий төлөвлөгөөний дагуу нийтийн болон хувийн орон сууцны **шинэ суурьшлын бүсүүдийг** байгуулна.

- 4.1.6 Гэр хорооллын газрыг **дахин төлөвлөх** ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
- 4.1.7 Орон сууцны 19 дүгээр хорооллын бүтээн байгуулалтыг эхлүүлж, үндсэн болон туслах тосгоны **дахин төлөвлөлтийг** үргэлжлүүлнэ.
- 4.1.8 Хотын цэвэрлэх байгууламжийг иж бүрэн шинэчилж дуусгана.
- 4.1.9 Гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн инженерийн дэд бүтцэд холбох ажлыг үргэлжлүүлнэ.
- 4.1.10 Хотын болон орон сууц, гэр хорооллын доторхи автозамын шинэчлэлтийг үргэлжлүүлнэ.
- 4.1.11 Нийтийн тээврийн үйлчилгээг ухаалаг болгож чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.1.12 Хотын ногоон байгууламжийг эрс нэмэгдүүлж, орчин үеийн архитектурын шийдэл бүхий мини цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулж, хуучныг нь сэргээн засварлана.
- 4.1.13 **“Найрамдал” талбайг** хөгжлийн орчин үеийн шинэ хандлагад нийцүүлэн шинэчилнэ.
- 4.1.14 **“Цэвэр хот”** төсөл хэрэгжүүлж, хотын соёлыг бий болгоно.
- 4.1.15 Дэд бүтцийг нь шийдвэрлэх замаар мал аж ахуй, туслах аж ахуйг хотын бүсээс гаргана.
- 4.1.16 Орчин үеийн шаардлагад нийцсэн **олон улсын тээвэр, ложистикийн төв** байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 4.1.17 Хотын хэмжээнд **“Уулзвар”** төсөл хэрэгжүүлж, зориулалтын гарц, тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, хяналтын камер, гэрлэн дохионы нэгдсэн сүлжээг бий болгоно.
- 4.1.18 Иргэдийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан зарим багуудад сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг, соёл, спортын төвүүд барина.
- 4.1.19 Хотоо иж бүрэн гэрэлтүүлэг, хяналтын камертай болгоно.
- 4.1.20 Хотын хэмжээнд 10-аас доошгүй км дугуйн зам барина.
- 4.1.21 Сургуулийн автобусны үйлчилгээг өргөжүүлж, цэцэрлэгийн хүүхдийн автобустай болно.

## 4.2 Сумдын хөгжил

### 4.2.1 Шарын гол сум

- 4.2.1.1 Уламжлалт нүүдлийн мал аж ахуйг эрчимжсэн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, хариуцлагатай уул уурхайтай хослуулан хөгжүүлэх бодлого баримтлана.
- 4.2.1.2 Дархан-Шарын гол чиглэлийн авто замын ажлыг гүйцээнэ.

4.2.1.3 Дулааны станцыг өргөтгөж, зарим хэсэгт дулааны шугамыг шинэчилнэ.

4.2.1.4 Цэвэрлэх байгууламжийг шинэчилж, Бууртын цэвэр усны эх үүсвэрийг хамгаалалтанд авч, бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.

4.2.1.5 Хуучин хөлбөмбөгийн талбайг сэргээж, спортын талбай байгуулна.

4.2.1.6 Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв байгуулна.

4.2.1.7 Санжинт багт шинээр цэцэрлэг байгуулна.

4.2.1.8 Соёлын төвийн барилга, спортын ордныг засварлана.

4.2.1.9 Амины орон сууцны шинэ суурьшлын бүсийн дэд бүтцийг шийдвэрлэж, хорооллын бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.

4.2.1.10 Ашиглалтын хугацаа дууссан насжилт өндөртэй барилгуудыг буулгаж, дахин төлөвлөлтөнд хамруулах ажлыг эхлүүлнэ.

4.2.1.11 Сумын төв доторхи гэрэлтүүлэг, нийтийн зориулалттай орон сууцны байруудын засвар үйлчилгээ, авто замын засвар шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлнэ.

4.2.1.12 Суманд мини усан сан байгуулна.

#### 4.2.2 Хонгор сум

4.2.2.1 Газар тариаланг эрчимжсэн мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх бодлого баримтлана.

4.2.2.2 Хонгор-Салхит чиглэлийн авто замыг бүрэн шинэчилнэ.

4.2.2.3 Сумын төвд амины орон сууцны шинэ суурьшлын бүс байгуулна.

4.2.2.4 Цэвэрлэх байгууламж, дулааны шугамыг шинэчилж, сумын төвийг хэрэглээний халуун устай болгож, ундны усны хатуулгийг бууруулах технологи нэвтрүүлнэ.

4.2.2.5 Сумын төв доторхи авто замуудыг шинэчлэн засварлана.

4.2.2.6 Эрүүл мэндийн төвийн байрыг өргөтгөнө.

4.2.2.7 Сумын төв болон Салхит багт үерийн далан байгуулна.

4.2.2.8 Соёлын төвийн барилгыг засварлана.

4.2.2.9 Салхит багийн цэцэрлэгийг өргөтгөж хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

4.2.2.10 "Атар-4" аяны хүрээнд газар тариалан, төмс, хүнсний ногооны дундын аж ахуй байгуулна.

4.2.2.11 Тариалангийн талбайг хашаажуулах ажлыг үргэлжлүүлнэ.

4.2.2.12 Эрчимжсэн мал ахуйг бодлогоор хөгжүүлнэ.

### 4.2.3 Орхон сум

4.2.3.1 Уламжлалт нүүдлийн мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуй, газар тариалантай хослуулан хөгжүүлэх бодлого баримтлана.

4.2.3.2 Цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, цэвэр усны эх үүсвэрийн худгуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, зарим газарт шинээр худаг гаргана.

4.2.3.3 Дулаан хангамжийн нэгдсэн төв станцын барилга байгууламжийг барих, шугам сүлжээг шинэчлэх ажлын зураг төсвийг хийлгэж, ТЭЗҮндэслэлийг боловсруулна.

4.2.3.4 Зөгий, гахай, шувуу зэрэг туслах аж ахуйдыг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.

4.2.3.5 Сүү боловсруулах, хөргөх цех барьж байгуулахыг бодлогоор дэмжиж ажиллана.

4.2.3.6 Шинээр 82 айлын амины орон сууцны хорооллын дэд бүтцийг үргэлжлүүлэн хийж, хорооллын бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.

4.2.3.7 Аялал жуулчлалын цогцолбор байгуулахыг бодлогоор дэмжинэ.

4.2.3.8 Энхтал багийн Бүрэнтолгой хэсэгт байнгын үйл ажиллагаатай цэцэрлэг байгуулж, сумын төвийн цэцэрлэг, Шар дэрсний цэцэрлэгийн салбар бүлгийг өргөтгөнө.

4.2.3.9 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэнэ.

4.2.3.10 Сумын төвийн зарим хэсэгт сайжруулсан шороон замыг хатуу хучилттай болгож, гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.

4.2.3.11 Сургууль, соёлын төвийн барилгад их засвар хийнэ.

4.2.3.12 Сургуулийн дотуур байр барина.

## Тав. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

*Хүний эрх, эрх чөлөөг хангасан ухаалаг, тогтвортой засаглал бүхий цахим технологид суурилсан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлд тулгуурласан төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.*

### 5.1 Иргэдэд ээлтэй төрийн үйлчилгээ

5.1.1 Төрийн байгууллагуудын ажил үүргийн давхардал, хийдлийг арилгаж, зохион байгуулалтын оновчтой, цомхон бүтцээр төрийн үйлчилгээг шуурхай хүргэнэ.

5.1.2 Аймаг, орон нутгийн хөгжлийн асуудлаар аливаа бодлогын баримт бичгүүдийг улс, аймгийн хөгжлийн урт хугацааны бодлогын үзэл баримтлалд тулгуурлан боловсруулж, төслийг иргэдээрээ урьдчилан хэлэлцүүлж, гарсан санал дээр үндэслэн шийдвэр гаргаж, хэрэгжүүлнэ.

5.1.3 Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэн, аж ахуйн нэгжээс гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэж, шийдвэрлэлтийн явц, хэрэгжилтийг цахимаар хянадаг болно.

5.1.4 Бүх салбарт төр, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, санаачилга, оролцоог дэмжинэ.

5.1.5 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ бүсдад давуу байдал олгохгүй байх, хувийн явцуу ашиг сонирхол үүсгэхгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлж, ажлын гүйцэтгэл, ёс зүй, хариуцлагыг шалгуур болгон үнэлж, зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцож ажиллана.

5.1.6 Төрийн жинхэнэ албан хаагчдыг сонгуулийн үр дүнгээс үл хамааран ажил гүйцэтгэх чадвар, шатлан дэвших зарчмын дагуу сонгон шалгаруулалтаар томилж, төрийн албанд тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

5.1.7 Төрийн албан хаагчдыг тасралтгүй сурган хөгжүүлж, мэдлэг, чадвар, хандлагыг эрс шинэчилнэ.

5.1.8 Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, “Түгжрэлгүй төрийн үйлчилгээ” нэвтрүүлж, зарцуулах хугацааг богиносгож, иргэдийн сэтгэл ханамжийн хөндлөнгийн судалгааг хагас жил тутамд авч, үнэлгээний системийг нэвтрүүлнэ.

5.1.9 Төрийн зарим чиг үүрэг (эрх олгох, хөндлөнгийн хяналт тавих, төсөл хэрэгжүүлэх, сургалт явуулах, санал асуулга явуулах гэх мэт) – ийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлнэ.

5.1.10 Төсөл, тендерийн шалгаруулалтыг ил тод, нээлттэй явуулж, тусгай сангуудын үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийг дэмжихэд чиглүүлж, олон нийтэд нээлттэй, хяналттай байлгана.

5.1.11 Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулж, хөнгөлөлттэй орон сууцаар хангах бодлого баримтлана.

5.1.12 Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө, жендерийн тэгш байдлыг хангуулж ажиллана.

5.1.13 Гадаад орнуудын ижил төстэй хотуудтай болон салбар хоорондын хамтын ажиллагааг эдийн засаг, нийгэм, соёл спорт, хүмүүнлэгийн бүхий л чиглэлээр өргөжүүлэн хөгжүүлнэ.

## 5.2 Ухаалаг төрийн үйлчилгээ

5.2.1 “Цахим Дархан” дэд хөтөлбөр хэрэгжүүлж, мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж, шат дамжлагыг цөөрүүлнэ.

5.2.2 Төрийн цахим үйлчилгээг шуурхай авах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “Нэг иргэн – Нэг бүртгэл” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



5.2.3 Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг байнга дээшлүүлнэ.

5.2.4 Их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, төрийн бус байгууллага, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах боломжийг бүрдүүлж, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.

5.2.5 Төрөөс аливаа зөвшөөрлийг олгоход бүрдүүлдэг бичиг баримтын бүрдлийг цахимаар бүрдүүлэх нөхцлийг бий болгож **“Цахим зөвшөөрөл”** төсөл хэрэгжүүлнэ.

5.2.6 Цахим орчны аюулгүй байдлыг хангуулж, цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадавхийг бэхжүүлнэ.

5.2.7 Гамшигт үзэгдэл (цаг агаарын аюулт үзэгдэл, ган, зуд, гал түймрийн аюул, халдварт өвчин гэх мэт)- ээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор **“Цахим сэрэмжлүүлэг – Дархан”** аппликейшнийг тогтмол ажиллуулна.

### 5.3 Эрх зүйн бодлого

5.3.1 Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор **“Эрх зүйн хөтөч”** төсөл хэрэгжүүлнэ.

5.3.2 Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйг таслан зогсоож, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллана.

5.3.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангуулах ажлыг нэгдсэн зохион байгуулалт, тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

5.3.4 Хууль хяналт болон цэрэгжсэн байгууллагуудын материаллаг баазыг дээшлүүлж, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, тогтмол хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

5.3.5 Гамшгийн үеийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх чадавхийг бэхжүүлж, гамшгийн эрсдлийг үнэлэх арга, аргачлал, загварчлалыг боловсруулж, эрсдлийн үнэлгээг тогтмол хийнэ.

5.3.6 Аюулгүйн нөөц бүрдүүлэх, хуваарилах, зохицуулалт хийх, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулж, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхийг бэхжүүлнэ.

5.3.7 Цэрэгжсэн байгууллагуудын хүний нөөц, хүч хэрэгслийг орон нутгийн бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд татан оролцуулна.

5.3.8 Салбарын алба хаагчдыг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх талаар дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО